



ДОРНОГОВЬ АЙМАГ  
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/188

Цагаандөрвөлж

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/188 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 07/35 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 4 дүгээр баг Улсын нөөцийн 153 дугаар салбарын зүүн урд талд төлөвлөлтийн нэгж талбарын 4862556 дугаар бүхий (10178 м<sup>2</sup>) газрыг төмөр замын гаалийн хянатын талбай (вагон засварын газар)-н зориулалтаар (уг газрын дуудлага худалдааны анхны үнэ 6,101,400 (зургаан сая нэг зуун нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгөөр газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохих журмын дагуу 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (Т.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Туул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНБААТАР

